

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/43/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: У.Ербол  
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Төлбөрийн акт .....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУГАТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА О.СЕРИКЖАН  
ТАНАА

2022.02.25 № 058  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайланд тайлагнасан 168.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 9.0 сая төгрөгийн аж ахуйн материалын тооллогын дүнг гаргаагүй, тооцоо хийж хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалт болон оршин байх, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,288,091.00</b>	<b>19,343,737.92</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	150.00	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	150.00	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	150.00	-
31211	Төрийн сангийн харилцах	150.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,150,760.00	6,945,458.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	298,958.22
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	6,646,500.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,150,760.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,150,760.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	6,137,181.00	12,398,279.70
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,111,591.00	3,371,422.00
35110	Тусгай зориулалттай материал	-	-
35130	Эм боох материал	3,111,591.00	3,371,422.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,025,590.00	9,026,857.70
35420	Аж ахуйн материал	-	9,026,857.70
35470	Бусад хангамжийн материал	3,025,590.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>469,928,651.83</b>	<b>473,701,496.64</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	469,928,651.83	473,701,496.64
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	463,336,651.83	467,109,496.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	435,785,201.92	435,785,201.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,155,815.56)	(46,827,244.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,519,172.00	83,519,172.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,371,841.84)	(37,462,758.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,446,669.03	52,302,422.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,322,463.56)	(24,332,463.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,042,955.00	33,011,955.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,797,725.16)	(29,077,288.35)
39217	Ном	190,500.00	190,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,592,000.00	6,592,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,592,000.00	6,592,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-IV</b>	<b>477,216,742.83</b>	<b>493,045,234.56</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>19,983,452.93</b>	<b>2,295,940.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	19,983,452.93	2,295,940.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	19,983,452.93	2,295,940.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8,704,017.93	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	11,279,435.00	2,295,940.00
41361	Байгууллагад төлөх өглөг	11,279,435.00	2,295,940.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>457,233,289.90</b>	<b>490,749,294.56</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	457,233,289.90	490,749,294.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	466,568,107.00	466,568,107.00
51101	Өмч: - төрийн	466,568,107.00	466,568,107.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(32,106,735.74)	1,409,268.92
51210	Өмнөх үеийн үр дүн	(32,106,735.74)	(32,106,735.74)
51220	Тайлант үеийн үр дүн	-	33,516,004.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,771,918.64	22,771,918.64
<b>6.0</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>477,216,742.83</b>	<b>493,045,234.56</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>502,437,455.00</b>	<b>630,977,244.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>150.00</b>	<b>9,026,857.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	150.00	9,026,857.70
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	150.00	9,026,857.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		9,026,857.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>502437305.00</b>	<b>621,950,386.56</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	421006600.00	452,049,800.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	31,500,000.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	389,506,600.00	452,049,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20976375.00	91,850,113.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,976,375.00	91,850,113.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29913400.00	22,254,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,913,400.00	22,254,500.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	0.00	19,766,753.56
133003	Хөрөнгийн		19,766,753.56
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	30,540,930.00	36,029,220.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,540,930.00	36,029,220.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>519,820,871.24</b>	<b>597,461,239.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>519,820,871.24</b>	<b>597,461,239.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	519,820,871.24	562,461,239.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	329,703,968.93	373,010,605.85
210101	Үндсэн цалин	231,587,768.93	240,759,205.85
210102	Нэмэгдэл	78,575,200.00	94,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,300,000.00
210104	Урамшуулал	19,541,000.00	31,845,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,040,006.00	46,514,750.00
210201	Тэтгэврийн даатгал	32,032,806.00	32,732,550.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,001,800.00	3,445,600.00
210203	ҮОМЦӨ-ний даатгал	2,401,400.00	2,756,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	600,400.00	689,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,003,600.00	6,891,000.00
<b>2103</b>	<b>Байршиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,461,308.00	18,515,555.00
210301	Гэрэл, цахилгаан	1,024,400.00	2,224,400.00
210302	Түлш, халаалт	42,436,908.00	16,291,155.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,753,406.00	29,342,599.00
210401	Бичиг хэрэг	1,547,900.00	3,230,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,295,506.00	21,977,086.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,668,200.00	1,556,113.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	241,800.00	1,450,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,128,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	55,102,509.00	54,348,729.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,408,995.00	38,515,979.50
210502	Хоол, хүнс	5,048,520.00	8,569,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,644,994.00	7,263,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,848,900.00	6,063,240.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,339,000.00	4,893,140.00
210604	Урсгал засвар	1,509,900.00	1,170,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	188,000.00	1,303,481.00
210702	Дотоод албан томилолт	188,000.00	1,303,481.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	246,900.00	1,524,300.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	234,100.00	360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		32,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,000,000.00
210807	Газрын төлбөр		35,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,800.00	76,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35475873.31</b>	<b>31,837,978.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,707,330.00	4,686,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,099,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,768,543.31	26,051,908.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>35,000,000.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>35,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		35,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-17383416.24</b>	<b>33,516,004.66</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(17,383,416.24)</b>	<b>33,516,004.66</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	466,568,107.00	22,771,918.64	-32,106,735.74	0.00	457,233,289.90
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	466,568,107.00	22,771,918.64	-32,106,735.74	0.00	457,233,289.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	466,568,107.00	22,771,918.64	-32,106,735.74	0.00	457,233,289.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			33,516,004.66		33,516,004.66
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	466,568,107.00	22,771,918.64	1,409,268.92	0.00	490,749,294.56

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>470,937,305.00</b>	<b>595,537,133.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>470,937,305.00</b>	<b>595,537,133.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>389,506,600.00</b>	<b>452,049,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	389,506,600.00	452,049,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>20,976,375.00</b>	<b>91,850,113.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,976,375.00	91,850,113.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>29,913,400.00</b>	<b>22,254,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,913,400.00	22,254,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,540,930.00</b>	<b>29,382,720.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,540,930.00	29,382,720.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>470,937,305.00</b>	<b>585,479,283.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>470,937,305.00</b>	<b>585,479,283.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>470,937,305.00</b>	<b>550,479,282.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>311,952,439.00</b>	<b>380,096,482.00</b>
210101	Үндсэн цалин	213,836,239.00	247,845,082.00
210102	Нэмэгдэл	78,575,200.00	94,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,300,000.00
210104	Урамшуулал	19,541,000.00	31,845,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,040,006.00</b>	<b>46,514,750.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,032,806.00	32,732,550.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,001,800.00	3,445,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,401,400.00	2,756,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	600,400.00	689,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,003,600.00	6,891,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,524,400.00</b>	<b>20,132,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,024,400.00	2,224,400.00
210302	Түлш, халаалт	27,500,000.00	17,907,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,240,836.00</b>	<b>29,211,299.50</b>
210401	Бичиг хэрэг	1,547,900.00	3,547,900.00
210402	Тээвэр, шатахуун	26,574,536.00	22,232,999.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,668,200.00	1,980,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	1,450,200.00	1,450,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,761,294.00</b>	<b>61,413,920.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,547,300.00	46,358,900.00
210502	Хоол, хүнс	8,569,000.00	8,569,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,644,994.00	6,486,020.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,848,900.00</b>	<b>6,393,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,339,000.00	2,955,700.00
210604	Урсгал засвар	1,509,900.00	3,437,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>188,000.00</b>	<b>2,425,431.00</b>
210702	Дотоод албан томиллолт	188,000.00	2,425,431.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>246,900.00</b>	<b>1,567,200.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	234,100.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		30,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар		45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,000,000.00
210807	Газрын төлбөр		35,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний	12,800.00	76,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,134,530.00</b>	<b>2,725,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,134,530.00	2,725,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>35,000,000.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>35,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		35,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>0.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		<b>10,057,850.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>10,058,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>10,058,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үсвэрээр</b>		<b>10,058,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,058,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(10,058,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>(150.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>150.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>150.00</b>	

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		150.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	501,455,100.00	501,455,099.50
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	501,455,100.00	501,455,099.50
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	501,455,100.00	501,455,099.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	344,551,700.00	344,551,700.00
210101	Үндсэн цалин	212,300,300.00	212,300,300.00
210102	Нэмэгдэл	94,106,400.00	94,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	6,300,000.00
210104	Урамшуулал	31,845,000.00	31,845,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ</b>	46,514,600.00	46,514,600.00
210201	Тэтгэврийн даатгал	32,732,400.00	32,732,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,445,600.00	3,445,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,756,500.00	2,756,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	689,100.00	689,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,891,000.00	6,891,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,932,200.00	18,932,200.00
210301	Гэрэл, цахилгаан	1,024,400.00	1,024,400.00
210302	Түлш, халаалт	17,907,800.00	17,907,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,211,300.00	29,211,299.50
210401	Бичиг хэрэг	3,547,900.00	3,547,900.00
210402	Тээвэр, шатахуун	22,233,000.00	22,232,999.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,200.00	1,980,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	1,450,200.00	1,450,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	45,047,500.00	45,047,500.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,558,900.00	31,558,900.00
210502	Хоол, хүнс	8,569,000.00	8,569,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,919,600.00	4,919,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,407,000.00</b>	<b>8,407,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,553,000.00	7,553,000.00
210604	Урсгал засвар	854,000.00	854,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,894,600.00</b>	<b>1,894,600.00</b>
210702	Дотоод албан томиллолт	1,894,600.00	1,894,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>1,567,200.00</b>	<b>1,567,200.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	30,000.00	30,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	45,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	35,900.00	35,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураангуй	76,300.00	76,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,329,000.00</b>	<b>5,329,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,329,000.00	5,329,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>501,455,100.00</b>	<b>503,687,019.50</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>452,049,800.00</b>	<b>452,049,799.50</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	452,049,800.00	452,049,799.50
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>19,786,200.00</b>	<b>22,254,500.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	19,786,200.00	22,254,500.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС</b>	<b>29,619,100.00</b>	<b>29,382,720.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,619,100.00	29,382,720.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>150.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>150.00</b>	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25.00</b>	<b>29.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	23.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	5.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.00</b>	<b>29.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (Т)	17.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	9.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>20976375.00</b>	<b>91,850,113.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>20976375.00</b>	<b>91,850,113.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	20976375.00	56,850,113.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	11773039.00	35,544,782.00
210101	Үндсэн цалин	11,773,039.00	35,544,782.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,515,806.00	-
210201	Тэтгэврийн даатгал	3,515,806.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	1,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан		1,200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,736,700.00	16,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,736,700.00	16,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	3,574,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		774,500.00
210604	Урсгал засвар		2,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	530,831.00
210702	Дотоод албан томилолт		530,831.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	950830.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	950,830.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	35,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	35,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		35,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	20976375.00	<b>91,850,113.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,976,375.00	<b>91,850,113.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,234,375.00	91,850,113.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	742,000.00	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Үйлчлэх хүрээний хүн амьд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд, чанартай, хүртээмжтэй үзүүлэх, байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж, үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоход цахим сүлжээг өргөнөөр ашиглах, хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 519.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.8 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.15	0.00	-0.15
Авлага	1150.7	6945.5	5794.8
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	6137.2	12398.3	6261.1
Үндсэн хөрөнгө	469928.6	473701.5	3772.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>477216.7</b>	<b>493045.2</b>	<b>15828.5</b>
Өр төлбөр	19983.4	2295.9	-17687.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	457233.3	490749.3	33516.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>477216.7</b>	<b>493045.2</b>	<b>15828.5</b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын данс үлдэгдэл 6.9 сая төгрөг болж 5.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.4 сая төгрөг болж 6.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 60.7 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 9.0 сая төгрөгийн бараа материалыг дээд шатны байгууллагаас шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 63.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 473.7 сая төгрөг болж 3.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, хандив тусламжаар 15.8 сая төгрөгийн, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын дагуу 3.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2.3 сая төгрөг болж 17.7 сая төгрөгөөр буусан нь оны эхний өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 490.7 сая төгрөг болж 33.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 630.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 128.5 сая төгрөгөөр буюу 25.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилт, эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилт, үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө, бараа материал байна.

Нийт зардал өмнөх оноос 77.6 сая төгрөгөөр буюу 14.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

Цалингийн зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, хангамж, материалын зардал, урсгал шилжүүлэг өмнөх оноос нэмэгдэж, байр ашиглахтай холбоотой зардал, нормативт зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны анх батлагдсан төсөв 501.4 сая төгрөг ба төсвийн тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Нийт зарлагын 452.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 19.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тусгажээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 501.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулсан боловч сумын төрийн сангийн мэргэжилтний буруугаас шалтгаалан орон нутгийн төсвөөс 2.2 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосноос гүйцэтгэлээр 503.6 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 2.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Нийт төсвийн 68.7 хувийг цалин, 9.3 хувийг НДШ-ийн зардал, 3.7 хувийг тогтмол зардал, 5.8 хувийг хангамж, бараа материалын зардал, 8.9 хувийг нормативт зардал, 1.6 хувийг эд хогшил, урсгал засвар 1.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.0 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 37.1 сая, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас 54.6 сая, нийт 91.8 төгрөгийн нэмэлт санхүүжилт авч Ковид-19 цар тахлын үед ажилласан ажиллагсдын цалин, урамшуулал, нэг удаагийн тэтгэмж болон бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан орон нутгийн төсвөөс илүү авсан санхүүжилтээс бусад холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн болно.

Ажиллагсдын цалингийн цэст цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, бусад нэмэгдлүүдийг дэлгэрэнгүй харуулаагүй, нийт нэмэгдлүүдийг нийлүүлж товчоо хэлбэрээр гаргасан, аудитын явцад цалингийн нэмэгдлүүдийг нэг бүрчлэн гаргаж тооцоо хийхэд, нягтлан бодогчийн тооцооноос 7588.0 мянган төгрөгийн зөрүүтэй, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан нэг бүрчлэн тулгаж баримтжуулах боломжгүй байсан.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 501.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас авлага, өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх 9.2 сая төгрөгийн 3 мэдээлэл, бусад мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар энэ зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар илүү олгосон цалин, урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, илүү орон тоо ажиллуулсны улмаас НДШ, цалингийн татварт 8.6 сая төгрөгийн, эмийн тооцоогоор 1.1 сая төгрөгийн авлага, 11.3 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, эмийн тайланг 5.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, 20.4 сая төгрөгийн тээвэр шатахууны материалын тайлан гаргаагүй, тээвэр шатахууны зардлаас 2.0 сая төгрөгийг эмийн зардалд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан, нийт 15.8 сая төгрөгийн зарцуулалтыг бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж, шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 3.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэж орлого аваагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг санхүүгийн тайлан дахь хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулах боломжгүй, өмнөх аудитаар НБББББ боловсруулж мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмж, орон тоо хэтрүүлж өр үүсгэсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нийт 68.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, шилэн дансны хугацаа хоцроож мэдээлсэн 38 мэдээлэлд зөвлөмж өгөгдсөн байна.

Давтан шалшаж үзэхэд 1.2 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, өр төлбөрийн ихэнх хувийг буюу 17.6 сая төгрөгийг барагдуулж, 3.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг г орлого авч данс бүртгэлд тусгасан, НБББББичиг боловсруулж мөрдөж ажилласан боловч тээвэр шатахууны зардлыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, жолоочийн тооцооны

хуудас дутуу хөтөлсөн, зарцуулсан шатахууны тооцоог хийж баримтжуулаагүй, эд хөрөнгийн тооллогыг бүрэн гүйцэд хийгээгүй, жилийн эцэст тооцоо нийлж ажиллаагүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж ирсэн зөрчлүүд нь арилаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, тээвэр шатахууны зардлыг гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй үзэх шаардлагатай.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 252.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13.0 сая төгрөгийн зөрчилд залруулга хийж, 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 237.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд машин тоног төхөөрөмж дансанд тусгасан 9.0 сая төгрөгийн бараа материал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд хандив тусламжаар буруу тайлагнасан 2.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтэд, санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд тавилга эд хогшлын 1.6 сая төгрөгийн элэгдлийн алдааг залруулсан болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар нийт 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тавигдсан болно. Үүнд:

1. Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 19.7 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 22.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 2.4 сая төгрөгийн санхүүжилтийг илүү авсныг сумын төрийн сангийн төлөөлөгч нь төсвийн ерөнхий орлогын дансанд буцаан төлүүлээгүй, нэр данс зөрүүтэй /300015/ гэсэн кодоор бүртгэж зардалд хамруулахгүйгээр зарлага гаргаж батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн 37.1.3, 37.1.7, 37.1.8, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2, 41.2.3, 41.2.4, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийн 64.1.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд нийцэхгүй байна

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар нийт 237.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгдсэн боловч 168833.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 9026.8 сая төгрөгийн аж ахуйн материалыг тооллогын дүнг гаргаагүй, хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, тооллоготой холбоотой өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан.

2.Тээвэр шатахууны зардалд зарцуулсан 22232.9 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, зарлагын гүйлгээг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн, жолоочийн тооцооны хуудсыг дутуу хөтөлсөн, зарцуулсан шатахууны тооцоог хийж баримтжуулаагүй, Түлш, халаалтын зардалд 17907.8 мянган төгрөгийг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн, тооцоо нийлээгүй, 2295.9 мянган төгрөгийн эмийн өглөгийн тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй.

3. Ажиллагсдын цалингийн цэст цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, бусад нэмэгдлүүдийг дэлгэрэнгүй харуулаагүй, нийт нэмэгдлийг нийлүүлж товчоо хэлбэрээр гаргасан, аудитын явцад цалингийн нэмэгдлүүдийг нэг бүрчлэн гаргаж тооцоо хийхэд,

нягтлан бодогчийн тооцооноос 7588.0 мянган төгрөгийн зөрүүтэй бөгөөд цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тулган баримтжуулах боломжгүй бана.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

1. 2021 онд нийт 501.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдэн цахим хуудаст ил тод байршуулахаас авлага, өглөг үүсгэсэн шийдвэрийн талаарх 9.2 сая төгрөгийн 3 мэдээлэл, бусад мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар энэ зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бугат сумын Эрүүл мэндийн төв	6	252.4	3	13.0	1	2.4	2	237.0		